



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



ГАЗАР ЗҮЙ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:


Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:


Сурагчийн код:

4. Доорх графикаас харахад Монгол орны хүн амын өсөлт хэдээс хэдэн онд 2-оос дээш хувийн өсөлттэй байсан байна вэ?



- A. 1963-1989 B. 1963 – 2020 C. 1989 – 2020 D. 1918 – 1956


5. Өгөгдсөн угсаатны хувцас болон газар зүйн тархацыг ажиглан ямар ястан болохыг сонгоорой.



- A. Дарьганга
B. Үзэмчин
C. Халх
D. Буриад

6. Монгол орны зүүн хэсэгт орших өндрийн хэлбэлзэл багатай 90 км урт, 60 гаруй км өргөн нутгийг эзлэн д.т.д 600 м-т оршино. Энд гадаргын ямар хэлбэр зонхилсон байна вэ?
A. цав толгод B. уулс C. ухаа гүвээ D. тэгш тал

7. Хаяалбар шугамыг уншиж огтлолын өндрийг тодорхойлоорой.



- A. 100 м
B. 50 м
C. 10 м
D. 0 м

8. Зурагт үзүүлсэн зүйлсийг үйлдвэрлэхэд ашиглагдах эрдэс, ашигт малтмалыг нэрлээрэй.




- A. шавар, шохой, гялтгануур
B. болор, шавар, цахиур
C. хөнгөн цагаан, зэс, төмөр
D. шавар, цахиур, мөнгө

9. Монгол орон дахь үлэг гүрвэлийн ул мөр олдсон газруудыг зурагт харуулав. Юрын галавын үеийн үлэг гүрвэл хамгийн их олдсон аймгийг таних тэмдэг ашиглан тодорхойлоорой.



А. Өмнөговь В. Баянхонгор С. Говь-Алтай Д. Дундговь


10. Цаг агаарын зургийн ажиглан өмнөд хэсгээр агаарын бага даралтын үзүүлэлт хэдэн гПа байгааг тодорхойлоорой.



- A. 996 гПа
- B. 1008 гПа
- C. 1012 гПа
- D. 1016 гПа


11. Цаг агаарын зургийг ажиглан ямар аймгийн ихэнх нутгаар цас орсон байгааг тодорхойлон сонгоорой.

Цаг агаарын үзэгдлийн мэдээлэл (2023-01-18 08:00)



- A. Хэнтий
- B. Сүхбаатар
- C. Архангай
- D. Завхан


12. Гол горхи эх аван урсдаг нуурыг урсгал нуур гэдэг. Доорх зургуудыг ажиглан урсгал нуурыг сонгоно уу.



13. Усны нөөцийг хадгалан үлдээхэд таны оролцоонд аль нь чухал вэ?

- A. Хур тунадас, үер усны аюул болохоос урьдчилан сэргийлэх
- B. Газар ухаж гол мөрний урсац, горимыг нэмэгдүүлэх
- C. Аж үйлдвэрлэлийн тоог нэмэгдүүлж, усыг цэвэршүүлэх
- D. Айл өрхүүд өдөр тутмын усны хэрэглээгээ багасгах

14. Монгол орны хувьд жилийн дундаж температур хамгийн бага, хур тунадасны хэмжээ хамгийн их үзүүлэлттэй байгалийн бүс аль нь байна вэ?



- A. ойт хээр
- B. хээр
- C. говь
- D. цөл

15. 2018 оны Монгол орны хүн амын нягтшлыг илэрхийлсэн зургийг ажиглан хамгийн бага нягтшилтай 3 аймгийг тодорхойлоорой.



- A. Дорнод, Сүхбаатар, Хэнтий
- B. Дорноговь, Дундговь, Говьсүмбэр
- C. Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай
- D. Завхан, Баянхонгор, Увс

16. А хот ЗУ102⁰, Б хот ЗУ108⁰-д, хоёулаа ХӨ46⁰ дээр оршдог бол хоёр хотын хоорондох зайг зэргэдийн нумын уртыг ашиглан тодорхойлоорой. (46⁰=77,5 км)
- A. 155 км B. 276 км C. 465 км D. 930 км

17. Уулсын тогтолцоог оргилтой нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--------------------|----------------------|
| 1) Алтайн нуруу | a. Мөнхсарьдаг уул |
| 2) Хангайн нуруу | b. Асралтхайрхан уул |
| 3) Хэнтийн нуруу | c. Хүйтэн уул |
| 4) Хөвсгөлийн уулс | d. Отгонтэнгэр уул |

- A. 1d,2a,3b,4c B. 1c,2d,3b,4a C. 1a,2b,3c,4d D. 1c,2b,3a,4d

18. Доорх мэдээллийг уншиж цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй.

..... нь шатах ашигт малтмалын төрөлд ордог бөгөөд тунамал хурдсанд үүсдэг. Говьсүмбэр аймгийн нутагт орших улсын чанартай ашиглагддаг орд газар нь нийт 29500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2,708.7 сая тонн нөөцтэй буюу Шинэ-Ус, Өехийн цагаан, Ногоон тойрмын гэсэн 3 хэсгүүдээс бүрдэнэ.

- | | |
|-----------------------|-----------------------|
| A. Газрын тос, Тамсаг | B. Нүүрс, Тавантолгой |
| C. Нүүрс, Шивээ-овоо | D. Мөнгө, Асгат |

19. Багануур дүүргийн 5 хоногийн цаг агаарын мэдээг ашиглан шөнийн дундаж температурыг тооцоолж олно уу.



- A. -4.6⁰C B. -23⁰C C. 4.6⁰C D. 23⁰C

20. Орхон гол нь Хангайн нурууны Суварга хайрхан (д.т.д 3021 м) уулаас эх авч 1124 км урсаад Сэлэнгэ мөрний баруун талд Сүхбаатар хотын дэргэд (д.т.д 601 м) нийлдэг хамгийн том цутгал нь юм. Уг голын хэвгийг тооцоолоорой.

Голын хэвгийг = (Голын эх авсан цэг – Голын цутгаж буй цэг) / Голын урт

- A. 0.17 м B. 2.15 м C. 3.15 м D. 3.22 м